



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: БНА-2021/69/СТА/ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Баянхонгор хот</p> <p>2021 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат</p> <p>Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn</p> <p>Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням</p> <p>Утас: 99442140 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Цэрэнчимэд</p> <p>Утас: 88117644 Цахим хаяг: tserenchimedb@audit.gov.mn</p>
----------------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	5
2.1.Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийгдсэн нэмэлт дансны гүйцэтгэлийн тайлан.....	12
3.Аудитын тайлан	12
3.1. Ерөнхий зүйл	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
Залруулсан алдаа	17
Аудитын зөвлөмж	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	18
4. Менежментийн захидал.....	18
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

**БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 7
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ц.НАСАНБАЯР ТАНАА**

2021.02.25 № 2/49

танай _____ -ны № _____ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулан биелэлтийг тооцон ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

2021 А4 ТООТ

• 005020139

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТӨРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

2.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	82,978,902.34	114,047,233.17
33	АВЛАГА	00.00	2,393,252.72
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	456,103.33
335	Бусад авлага	00.00	1,937,149.39
3351	Байгууллагаас авах авлага	00.00	1,257,149.39
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	680,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	82,978,902.34	111,653,980.45
354	Хангамжийн материал	79,363,902.34	111,653,980.45
35410	Бичиг хэргийн материал	16,102,535.00	16,168,169.11
35420	Аж ахуйн материал	24,336,250.00	47,216,694.00
35430	Сэлбэг хэрэгсэл	6,687,003.40	5,146,003.40
35470	Бусад хангамжийн материал	32,238,113.94	43,123,113.94
35600	Мал амьтад	3,615,000.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,172,508,872.39	1,553,751,689.95
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,172,508,872.39	1,553,751,689.95
392	Биет хөрөнгө	1,088,006,872.46	1,469,449,690.06
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,070,514,791.10	1,426,370,791.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	-142,455,000.54	-193,599,435.62
39203	Авто-тээврийн хэрэгсэл	133,701,936.00	140,084,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-61,898,457.66	-70,413,787.82
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	131,229,123.00	197,268,290.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-99,963,212.98	-96,944,166.94
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	111,907,299.58	114,407,299.58
39208	Хуримтлагдсан элэгдэл	-55,029,606.04	-64,323,058.57
39214	Бусад үндсэн хөрөнгө	00.00	16,900,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-301,041.67
393	Биет бус хөрөнгө	84,501,999.93	84,301,999.89
39301	Програм хангамж	1,920,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,470,000.07	-1,250,000.11
39303	Бусад биет бус хөрөнгө	84,052,000.00	84,052,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,255,487,774.73	1,667,798,923.12
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	456,103.33
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	456,103.33
413	Өглөг	00.00	456,103.33
4136	Бусад өглөг	00.00	456,103.33
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	456,103.33
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,255,487,774.73	1,667,342,819.79
51	Засгийн газрын хувь оролцоо	1,255,487,774.73	1,667,342,819.79
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	876,709,433.09	876,709,433.09
51101	Өмч: - төрийн	876,709,433.09	876,709,433.09
512	Хуримтлагдсан үр дүн	8,598,553.93	426,052,025.84
51210	Өмнөх үеийн үр дүн	8,598,553.93	14,196,980.78

Баянхонгор сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51220	Тайлант үеийн үр дүн	00.00	411,855,045.06
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	370,179,787.71	364,581,360.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,255,487,774.73	1,667,798,923.12

2.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,492,739,472.00	2,466,006,593.11
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	40,652,272.00	448,583,734.11
120	Нийтлэг татварын бус орлого	40,652,272.00	448,583,734.11
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	40,652,272.00	448,583,734.11
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	5,790,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	40,502,272.00	442,793,134.11
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,452,087,200.00	2,017,422,859.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	69,844,700.00	378,053,259.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	139,111,177.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	69,844,700.00	238,942,082.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,382,242,500.00	1,639,369,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,382,242,500.00	1,639,369,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,509,115,096.83	2,037,292,183.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,509,115,096.83	2,037,292,183.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,505,328,288.29	1,949,300,529.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	522,683,735.83	601,480,951.91
210101	Үндсэн цалин	522,683,735.83	601,480,951.91
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,788,159.87	75,998,568.25
210201	Тэтгэврийн даатгал	46,535,707.70	52,679,895.38
210202	Тэтгэмжийн даатгал	5,239,948.66	6,342,686.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,189,576.95	4,872,549.47
210204	Ажилгүйдлийн даатгал	1,009,180.24	1,096,941.76
210205	Эрүүл мэндийн даатгал	9,813,746.32	11,006,494.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,847,254.82	73,096,290.62
210301	Гэрэл, цахилгаан	7,812,397.52	13,695,160.12
210302	Түлш, халаалт	50,007,263.00	56,374,174.50
210303	Цэвэр, бохир ус	3,027,594.30	3,026,956.00
2104	Хангамж, бараа материалын зардал	53,397,917.94	123,848,400.42
210401	Бичиг хэрэг	13,625,750.00	16,215,020.00
210402	Тээвэр, шатахуун	23,640,000.00	30,484,900.00

Баянхонгор сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,284,004.94	11,521,480.42
210404	Ном, хэвлэл	921,400.00	1,871,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	58,246,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,829,560.00	4,247,400.00
210408	Бараа материал акталсны зардал	2,097,203.00	1,261,900.00
2105	Нормативт зардал	450,000.00	3,920,000.00
210502	Хоол, хүнс	450,000.00	3,140,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	780,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,238,012.20	9,110,640.00
210602	Тавилга	145,000.00	00.00
210604	Урсгал засвар	5,093,012.20	9,110,640.00
2107	Томилолт, зочны зардал	9,858,059.00	465,000.00
210701	Гадаад албан томилолт	5,905,059.00	00.00
210702	Дотоод албан томилолт	3,953,000.00	465,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	650,348,087.00	879,713,522.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	650,348,087.00	879,713,522.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	135,717,061.63	181,667,156.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,671,830.00	79,644,438.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	618,000.00	1,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	84,427,231.63	101,022,718.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,786,808.54	87,991,654.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,690,000.00	4,290,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,690,000.00	4,290,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	41,426.54	83,701,654.41
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	41,426.54	68,095,472.41
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	55,382.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	55,382.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-16,375,624.83	428,714,409.34
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	303,437.38	16,859,364.28
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	303,437.38	16,859,364.28
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-303,437.38	-16,859,364.28
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-16,679,062.21	411,855,045.06

2.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,453,020,874.00	2,023,213,459.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	150,000.00	5,790,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	150,000.00	5,790,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	150,000.00	5,790,600.00

Баянхонгор сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	5,790,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,452,870,874.00	2,017,422,859.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	69,844,700.00	378,053,259.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	139,111,177.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	69,844,700.00	238,942,082.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,382,242,500.00	1,639,369,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,382,242,500.00	1,639,369,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	783,674.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	783,674.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,435,121,874.00	1,966,853,559.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,435,121,874.00	1,966,853,559.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,425,060,191.46	1,878,861,904.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	522,637,995.70	585,652,800.49
210101	Үндсэн цалин	522,637,995.70	585,652,800.49
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,833,900.00	75,084,869.06
210201	Тэтгэврийн даатгал	45,552,000.00	52,322,901.31
210202	Тэтгэмжийн даатгал	5,320,500.00	6,193,486.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,256,400.00	4,725,149.29
210204	Ажилгүйдлийн даатгал	1,064,100.00	1,104,896.02
210205	Эрүүл мэндийн даатгал	10,640,900.00	10,738,435.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,887,254.82	73,096,290.62
210301	Гэрэл, цахилгаан	5,852,397.52	6,661,287.12
210302	Түлш, халаалт	50,007,263.00	63,408,047.50
210303	Цэвэр, бохир ус	3,027,594.30	3,026,956.00
2104	Хангамж, бараа материалын зардал	52,230,214.94	122,777,100.42
210401	Бичиг хэрэг	13,721,660.00	16,116,120.00
210402	Тээвэр, шатахуун	23,640,000.00	30,484,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,416,094.94	11,583,980.42
210404	Ном, хэвлэл	941,400.00	1,871,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	58,246,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,511,060.00	4,474,400.00
2105	Нормативт зардал	00.00	8,820,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	8,820,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,024,050.00	9,132,540.00
210602	Тавилга	1,143,000.00	499,500.00
210604	Урсгал засвар	8,881,050.00	8,633,040.00
2107	Томилолт, зочны зардал	9,858,059.00	465,000.00
210701	Гадаад албан томилолт	5,825,559.00	00.00

Баянхонгор сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	4,032,500.00	465,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	648,275,887.00	897,712,922.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	648,275,887.00	897,712,922.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,312,830.00	106,120,382.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,694,830.00	104,120,382.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	618,000.00	2,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,061,682.54	87,991,654.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,473,674.00	4,290,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	783,674.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,690,000.00	4,290,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	41,426.54	83,701,654.41
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	41,426.54	68,095,472.41
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,546,582.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,546,582.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>17,899,000.00</u>	<u>56,359,900.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	17,899,000.00	56,359,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,899,000.00	56,359,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	17,899,000.00	56,359,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,899,000.00	56,359,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-17,899,000.00</u>	<u>-56,359,900.00</u>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

/төгрөг/

2.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,709,433.09	370,179,787.71	2,513,526.10	1,249,402,746.90
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	876,709,433.09	370,179,787.71	2,513,526.10	1,249,402,746.90
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-16,679,062.21	-16,679,062.21
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,709,433.09	370,179,787.71	8,598,553.93	1,255,487,774.73
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,709,433.09	370,179,787.71	8,598,553.93	1,255,487,774.73

Баянхонгор сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	5,598,426.85	5,598,426.85
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	876,709,433.09	370,179,787.71	14,196,980.78	1,261,086,201.58
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-5,598,426.85	00.00	-5,598,426.85
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	411,855,045.06	411,855,045.06
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,709,433.09	364,581,360.86	426,052,025.84	1,667,342,819.79

2.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,641,869,600.00	1,577,064,727.59	64,804,872.41	96.1
УРСГАЛ ЗАРДАЛ	1,641,869,600.00	1,577,064,727.59	64,804,872.41	96.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,610,869,200.00	1,572,774,727.59	38,094,472.41	97.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	604,877,100.00	585,652,800.49	19,224,299.51	96.8
Үндсэн цалин	604,877,100.00	585,652,800.49	19,224,299.51	96.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,157,900.00	75,084,869.06	7,073,030.94	91.4
Тэтгэврийн даатгал	57,814,700.00	52,322,901.31	5,491,798.69	90.5
Тэтгэмжийн даатгал	6,085,800.00	6,193,486.84	(107,686.84)	101.8
ҮОМШӨ-ний даатгал	4,868,600.00	4,725,149.29	143,450.71	97.1
Ажилгүйдлийн даатгал	1,217,200.00	1,104,896.02	112,303.98	90.8
Эрүүл мэндийн даатгал	12,171,600.00	10,738,435.60	1,433,164.40	88.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	81,393,000.00	73,096,290.62	8,296,709.38	89.8
Гэрэл, цахилгаан	10,114,100.00	6,661,287.12	3,452,812.88	65.9
Түлш, халаалт	66,226,500.00	63,408,047.50	2,818,452.50	95.7
Цэвэр, бохир ус	5,052,400.00	3,026,956.00	2,025,444.00	59.9
Хангамж, бараа материалын зардал	124,032,600.00	122,777,100.42	1,255,499.58	99.0

Баянхонгор сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бичиг хэрэг	16,152,000.00	16,116,120.00	35,880.00	99.8
Тээвэр, шатахуун	30,840,000.00	30,484,900.00	355,100.00	98.8
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,056,400.00	11,583,980.42	472,419.58	96.1
Ном, хэвлэл	2,263,600.00	1,871,500.00	392,100.00	82.7
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	58,246,200.00	58,246,200.00	-	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,474,400.00	4,474,400.00	-	100.0
Нормативт зардал	8,820,000.00	8,820,000.00	-	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,820,000.00	8,820,000.00	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	42,050,000.00	42,032,440.00	17,560.00	100.0
Тавилга	2,000,000.00	1,999,400.00	600.00	100.0
Урсгал засвар	40,050,000.00	40,033,040.00	16,960.00	100.0
Томилолт, зочны зардал	1,600,000.00	465,000.00	1,135,000.00	29.1
Дотоод албан томилолт	1,600,000.00	465,000.00	1,135,000.00	29.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	558,716,300.00	558,425,845.00	290,455.00	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	558,716,300.00	558,425,845.00	290,455.00	99.9
Бараа үйлчилгээний бусад зардал	107222300.00	106420382.00	801,918.00	99.3
Бараа үйлчилгээний бусад зардал	104,922,300.00	104,420,382.00	501,918.00	99.5
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,300,000.00	2,000,000.00	300,000.00	87.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31000400.00	4290000.00	26,710,400.00	13.8
Бусад урсгал шилжүүлэг	31,000,400.00	4,290,000.00	26,710,400.00	13.8
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,500,400.00	00.00	26,500,400.00	-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,500,000.00	4,290,000.00	210,000.00	95.3
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,641,869,600.00	1,577,064,727.59	64,804,872.41	96.1
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,639,369,600.00	1,574,564,727.59	64,804,872.41	96.0
Орон нутгийн төсвөөс	1,639,369,600.00	1,574,564,727.59	64,804,872.41	96.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,500,000.00	2,500,000.00	-	100.0
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,500,000.00	2,500,000.00	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	63	63	-	100.0

Баянхонгор сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Удирдах ажилтан	03	03	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	51	51	-	100.0
Үйлчлэх ажилтан	09	09	-	100.0

2.6 Аудит хийгдсэн нэмэлт дансны гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Үзүүлэлт	төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		362,447,077.00
УРСГАЛ ЗАРДАЛ		362,447,077.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		362,447,077.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		362,447,077.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		362,447,077.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	362,447,077.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		362,447,077.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		123,504,995.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		238,942,082.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баянхонгор сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг ЗДТГ-ын дарга Ц.Насанбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав

Аудитыг 2021.02.02-ээс 2021.02.25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021.02.23-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Баянхонгор сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтээ Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020.10.26-ны өдрийн 3/376 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянхонгор аймгийн Баянхонгор сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг “Монгол улсын Засгийн газар, аймгийн ИТХ, Засаг даргаас тавьж буй хөтөлбөр зорилтыг хэрэгжүүлэх, сум, орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн тогтвортой байдлыг хангах, хууль ёсыг чандлан сахиулж, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй шуурхай хүргэхэд оршино” гэж тодорхойлжээ.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор аймгийн Баянхонгор сумын ЗДТГ-ын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт зардлын 326544.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 6530.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 456336.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 9126.7 мянган төгрөгөөр материаллаг байдлын суурийн дахин тооцсон.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 412311.1 мянган төгрөгөөр буюу 32.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	82,978.9	114,047.2	31,068.3
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	2,393.3	2,393.3
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	82,978.9	111,654.0	28,675.1

Баянхонгор сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,172,508.9	1,553,751.7	381,242.8
Үндсэн хөрөнгө	1,533,325.1	1,980,583.2	447,258.0
Хуримтлагдсан элэгдэл	(360,816.3)	(426,831.5)	(66,015.2)
Нийт хөрөнгө	1,255,487.8	1,667,798.9	412,311.1
Өр төлбөр	-	456.1	456.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,255,487.8	1,667,342.8	411,855.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,255,487.8	1,667,798.9	412,311.1

Эх сурвалжийг/ Санхүүгийн тайлангаас авав/

Бараа материалын үлдэгдэл 111654.0 мянган төгрөг болж 28675.1 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал 22880.4 мянга, бусад хангамжийн материал 10885.0 мянга, бичиг хэргийн материал 65.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, мал амьтад 3615.0 мянга, сэлбэг хэрэгсэл 1541.0 мянган төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 1980583.2 мянган төгрөг болж 447258.0 мянган төгрөгөөр өссөн нь Барилга байгууламж 355856.0 мянга, тээврийн хэрэгсэл 6382.8 мянга, машин, тоног төхөөрөмж 66039.2 мянга, тавилга 2500.0 мянга, бусад үндсэн хөрөнгө 16900.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, программ хангамж 420.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1667342.8 мянган төгрөг болж 411855.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн 411855.0 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 2466006.6 мянган төгрөг болж өмнөх оноос 973267.1 мянган төгрөгөөр буюу 65.2 хувиар өссөн байна.

Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 402290.8 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 5790.6 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 308208.5 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Нийт үйл ажиллагааны зардал 2037292.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 528177.1 мянган төгрөгөөр буюу 35.0 хувиар өссөн байна. Энэ нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-ын зардал 88007.6 мянга, байр ашиглалтын тогтмол зардал 12249.0 мянга, хангамжийн зардал 70450.5 мянга, норматив зардал 3470.0 мянга, эд хогшил, урсгал засварын зардал 3872.6 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 229365.4 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 45950.1 мянга, урсгал шилжүүлгийн зардал 600.0 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд

захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1612370.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1612370.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, батлуулсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1641869.6 мянган төгрөг батлагдсанаас 1 удаагийн зохицуулалт хийж 29499.5 мянган төгрөгөөр хасаж 1639369.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 2500.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 1641869.6 мянган төгрөгийн батлагдсан төсвөөс орон нутгийн төсвөөс 1639369.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлогоор 5790.6 мянган төгрөг оруулж, нийт 1641869.6 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Тайлант хугацаанд үйл ажиллагааны зардалд 1577064.7 мянган төгрөгийг зарцуулж, 64804.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1577064.7 мянган төгрөг буюу 86.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардал 24794.3 мянга, баг хорооны үйл ажиллагааны зардал 39301.7 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмж 210.0 мянга, орон нутгийн нөөц хөрөнгө 475.7 мянга, ангилагдаагүй бусад зориулалтын зардал 23.2 мянган төгрөгөөр тус тус дутуу хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
ХӨТӨЛБӨР 70106 /НИЙТ ДҮН/	1,641,869.6	1,577,064.7	64,804.9	96.1
АРГА ХЭМЖЭЭ 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	590,041.7	565,247.4	24,794.3	95.8
АРГА ХЭМЖЭЭ 80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал	334,633.9	295,332.2	39,301.7	88.3
АРГА ХЭМЖЭЭ 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	4,500.0	4,290.0	210.0	95.3
АРГА ХЭМЖЭЭ 81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	90,000.0	89,524.3	475.7	99.5
АРГА ХЭМЖЭЭ 82212 Хур хог хаягдал орчны бохирдол	553,694.0	553,694.0	-	100.0
АРГА ХЭМЖЭЭ 83201 Ангилагдаагүй бусад зориулалт	69,000.0	68,976.8	23.2	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,641,869.6	1,577,064.7	64,804.9	96.1
Орон нутгийн төсвөөс	1,639,369.6	1,574,564.7	64,804.9	96.0
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,500.0	2,500.0	-	100.0

Баянхонгор сумын ЗДТГ нь 1 хөтөлбөр, 6 арга хэмжээгээр төсвийг баталж зарцуулж байгаа бөгөөд зардлын хэтрэлт хэмнэлтийг дэлгэрэнгүй байдлаар харуулсан хүснэгийг ажлын баримтад хавсаргасан болно.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 378053.2 мянган төгрөгийн орлого төвлөрч 362447.0 мянган төгрөг зарцуулж, 15606.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

	үзүүлэлт	Хаанаас	орлого	зарлага	Хэмнэлт
1	Багийн иргэдийн урамшууллын зардал	Аймгийн ЗДТГ	6,000.0	4,800.0	1,200.0
2	Баланк, тоотны төлбөр	Багийн ЗД	43.2		43.2
3	Гуталчдаас барилгын засварт	Иргэд	1,800.0	1,800.0	-
4	Зорилтот бүлгийн санхүүжилт	ХЗДХЯ	6,881.4	6,881.4	-
5	Иргэдийн газар тариалан эрхлүүлэх ажлыг дэмжих	Аймгийн ЗДТГ	60,000.0	58,249.6	1,750.4
6	Мал тооллогын арга хэмжээний зардал	Статистикийн хэлтэс	869.1	869.1	-
7	Маскны үнэ	ААН	1,800.0	1,800.0	-
8	Огтоно устгалын зардал	ХХААГазар	4,320.0	4,320.0	-
9	Судалгааны зардал	Статистикийн хэлтэс	342.1	342.1	-
10	Тендерийн баримт бичиг	ТӨБЗГазар	959.0	924.0	35.0
11	Төрийн албан хаагчийн орон сууцны дэмжлэг	Аймгийн ЗДТГ	5,000.0	5,000.0	-
12	Улаан хивэгний үнэ	Иргэд	2,815.4	2,815.4	-
13	Өмнөх оны өвсний үнэ	Аймгийн ЗДТГ	5,546.6	5,540.0	6.6
14	Утаагүй Баянхонгор төсөл	Аймгийн ЗДТГ	62,189.0	49,924.0	12,265.0
15	Гэр хорооллын өрхүүдэд олгосон цахилгаан халаагуурын үнэ	Иргэд	18,870.9	18,480.0	390.9
16	ААН-ээс хогны төлбөр	ААН	8,950.0	8,650.0	300.0
17	Шаргалжуут наадмын зардал	Шаргалжуут рашаан сувилал	1,206.5	1,200.0	6.5
18	Шинэ суурьшлын бүсийн хашааны иргэдээс авч, ...шилжүүлсэн.	Иргэд	190,460.0	190,460.0	-
19	ХААН өртгийн судалгааны үнэ	Статистикийн хэлтэс		391.0	(391.0)
20	төвлөрүүлсэн гүйлгээ			15,606.2	(15,606.2)
	НИЙТ ДҮН		378,053.2	378,052.8	

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн

агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллийн сайтад нийт 27 төрлийн 151 мэдээлэл байршуулахаас 138 мэдээллийг хугацаанд нь, 234545.5 мянган төгрөгийн 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээлэл байршуулах хугацаа болоогүй байна.

Эх сурвалжийг/ байгууллагын шилэн данснаас авав/

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өнгөрсөн оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй, шилэн дансанд 1132.0 мянган төгрөгийн мэдээлэл байршуулах 1 албан шаардлага, 4 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилтийг 2020.03.26-ны 2/40 тоот албан бичгээр ирүүлсэн байна. Гэвч ажиллагсдын оронтоо илүү ажиллуулсантай холбоотой өгсөн "Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хэрэгжүүлж, хууль, тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах, **батлагдсан орон тооны хязгаарыг мөрдөж ажиллах**" гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Тухайлбал аймгийн Засаг даргын 2019.12.03-ны А/634 тоот захирамжаар Баянхонгор сумын ЗДТГ-ын орон тоог 54 байхаар тогтоож өгсөн байхад Баянхонгор сумын ЗДТГ-ын даргын 2020.01.02-ны А/01 тоот тушаалаар 69 орон тоо баталж, гүйцэтгэлээр 69 орон тоогоор ажиллаж байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар санхүүгийн тайланд хийсэн аудитаар Баянхонгор сумын ЗДТГ-ын дарга Ц.Насанбаярын 2018.10.17-ны Б/136 дугаар тушаалаар ЗДТГ-ын багийн нийгмийн ажилтан Б.Наранчимэгийг ажлаас чөлөөлсөн бөгөөд Б.Наранчимэг нь Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргаснаар Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020.08.08-ны 131/ШШ2020/00973 дугаар шийдвэрээр иргэн Б. Наранчимэгийн цалин, НДШ-ийн нөхөн олговорт 1008932 төгрөг олгож, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна. Мөн шилэн дансны сайтад мэдээллийг дутуу оруулсан, аймгийн Сум дундын ойн ангиас нийлүүлсэн 9600.0 мянган төгрөгийн өвс тэжээлийн орлого, зарлагын бүртгэл, авлага, өглөгийн тооцоо хийгээгүй зөрчил илэрлээ.

Ой ангиас ирүүлсэн судалгаа, тооцоогоор тус суманд 9600.0 мянган төгрөгийн өвс олгосон бөгөөд 4907.0 мянган төгрөг төлөгдсөн, 4693.0 мянган төгрөг төлөгдөөгүй байна.

Залруулсан алдаа

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгээгүй болно.

Аудитын зөвлөмж

Аудитаар шилэн дансны мэдээлэлд 234545.5 мянган төгрөгийн 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан тул 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Аудитын хугацаанд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар хийгдсэн ажил гүйлгээ буюу “Шинэ суурьшлын бүсийн хашаа”, “Утаагүй Баянхонгор” төсөл, “Гэр хороололд айл өрхөд нийлүүлсэн цахилгаан халаалт”-ын санхүүжилт, зарцуулалт, өвс, тэжээлийн орлого зарлагын тооцоог аудитын сорилд нарийвчлан хамруулаагүй тул дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

Мөн өмнөх оны аудитаар өгсөн “Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хэрэгжүүлж, хууль, тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах, **батлагдсан орон тооны хязгаарыг мөрдөж ажиллах**” гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байх тул зөрчлийг Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн аудитаар авч үзэх.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Шилэн дансны мэдээллийн сайтад нийт 27 төрлийн 151 мэдээлэл байршуулахаас 138 мэдээллийг хугацаанд нь 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4-р зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх", 6-р зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" заалтыг тус тус зөрчсөн байна.

1.2 Эрсдэл: Хөрөнгийн зарцуулалтын ил, тод байдлыг хангахгүй байх

1.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн дагуу шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж байх.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг давтан гаргахгүй, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



Б.ЦЭРЭНЧИМЭД 2021.02.25

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ 2021.02.25

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ 2021.02.25



Баянхонгор сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.12.31	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: БНА-2021/173/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Баянхонгор аймгийн Баянхонгор аймгийн Баянхонгор сумын ЗДТГ-ын		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Сум дундын ойн ангиас нийлүүлсэн 9600.0 мянган төгрөгийн өвс тэжээлийг орлого, зарлагын бүртгэлд тусгаагүй, дутуу төлсөн 4903.0 мянган төгрөгийг өглөгийн дансанд бүртгээгүй байна.	4693.0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Ц.Насанбаяр, Б.Даваажаргал
2	Баянхонгор сумын ЗДТГ-ын дарга Ц.Насанбаярын 2018.10.17-ны Б/136 дугаар тушаалаар ЗДТГ-ын багийн нийгмийн ажилтан Б.Наранчимэгийг ажлаас чөлөөлсөн бөгөөд Б.Наранчимэг нь Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргаснаар Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020. 08.08-ны 131/ШШ2020/00973 дугаар шийдвэрээр иргэн Б. Наранчимэгийн цалин, НДШ-ийн нөхөн олговорт 1008932 төгрөг олгосон байна.	1008.9	Албан шаардлага	Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны дарга	Б.Даваажаргал
3	Шилэн дансны мэдээллийн сайтад нийт 27 төрлийн 151 мэдээлэл байршуулахаас 138 мэдээллийг хугацаанд нь 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	0	зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Ц.Насанбаяр, Б.Даваажаргал
ДҮН		5701.9			

---- оОо ----